



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 14

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 03 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сайнцагаан суманд барьж, ашиглалтад оруулсан нийт 10,147,291,762 (арван тэрбум нэг зуун дөчин долоон сая хоёр зуун ерэн нэгэн мянга долоон зуун жаран хоёр) төгрөгийн өртөгтэй барилга байгууламжийг Нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Г.Тувааны нэрэмжит Нэгдсэн эмнэлгийн дарга (Э.Энхзориг)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 5 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн
... тогтоолын хавсралт



Нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд
бүртгэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Биет хэмжээ	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	100 ортой нэгдсэн эмнэлгийн барилга	м.кв	6018		9,887,662,845
2	Гадна дулаан	м	85	1,061,180	90,200,300
3	Гадна ус хангамж	м	45	66,141	2,976,345
4	Гадна бохир усны шугам	м	39	235,341	9,178,299
5	Гадна холбоо	м	65	485,331	31,546,515
6	Гадна цахилгаан				
	- дэд өртөө	ш	1	25,811,743	25,811,743
	- Цахилгааны шугам	м	438	131,793	57,725,334
7	Гадна тохижилт				
	Бетон зам талбай, зогсоол	м.кв	746	48,729	36,351,834
	Ногоон байгууламж				
	- Зүлэг	м.кв	83	36,609	3,038,547
	- Мод	ш	26	50,000	1,300,000
	Гэрэлтүүлэг	ш	3	500,000	1,500,000
Нийт төсөвт өртөг					10,147,291,762 (арван тэрбум нэг зуун дөчин долоон сая хоёр зуун ерэн нэгэн мянга долоон зуун жаран хоёр) төгрөг